



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний төвийн 2024
оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: ӨВА-2025/031/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2025 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: erdenetsetsegb@audit.gov.mn

Чадварлаг Аудит ХХК-ийн захирал: Д.Рэнцэнханд

Утас: 99200034 Цахим хаяг: chadvarlagAudit@gmail.com

Аудитор: П.Байгальмаа

Утас: 99038857 Цахим хаяг: baigal0508@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Хараат бус аудиторын дүгнэлт



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндангийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvorkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.01.14 № 19
танай _____-ны № _____-т

Г ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА Ч.ЧАНЦАЛДИЙМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өвөрхангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Өвөрхангай аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/77 дугаар захирамжаар Хужирт сумын Цаг уурын өртөөний улсын төсвийн санхүүжилтээр баригдсан 222.8 сая төгрөгийн барилгыг хөрөнгөнд бүртгэсэн байна. Цаг уур, орчны шинжилгээний газраас 128.9 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу үнэ төлбөргүй шилжин ирснийг бүртгэсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 792 дугаар тогтоолоор 35.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 818 дугаар тогтоолоор 30.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

015030136

D \Auditin gazaribaiguullagiiin dotood banmivA4

Тайлант онд улсын болон орон нутгийн төсвөөс 3,288.2 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 10.4 сая төгрөг төвлөрүүлснийг тус тус зарцуулсан байна. Мөнгөн хөрөнгийн зарцуулагдаагүй төсвийн үлдэгдэл 11.7 сая төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,793,957.24	55,466,849.44
35	БАРАА МАТЕРИАЛ	13,793,957.24	55,466,849.44
351	Түүхий эд материал	3,313,557.24	12,272,599.24
35110	Тусгай зориулалттай материал	3,313,557.24	12,272,599.24
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,400,000.00	1,940,000.00
354	Хангамжийн материал	7,080,400.00	41,254,250.20
35410	Бичиг хэргийн материал	1,066,500.00	828,700.00
35420	Аж ахуйн материал	942,850.00	24,741,820.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	6,656,180.20
35470	Бусад хангамжийн материал	5,071,050.00	9,027,550.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,520,329,603.77	1,893,566,832.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,520,329,603.77	1,893,566,832.60
392	Биет хөрөнгө	1,073,331,683.85	1,445,271,412.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	839,298,776.00	1,062,098,755.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(81,869,636.52)	(113,624,317.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	101,927,573.78	105,627,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(33,162,637.92)	(47,440,844.61)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	639,277,596.19	810,545,757.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(396,895,500.52)	(381,695,703.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,839,832.38	22,457,902.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,084,319.54)	(12,697,709.90)
393	Биет бус хөрөнгө	446,997,919.92	448,295,419.88
39301	Програм хангамж	475,000.00	1,975,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(255,000.08)	(457,500.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	446,777,920.00	446,777,920.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,534,123,561.01	1,949,033,682.04
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,534,123,561.01	1,949,033,682.04
51	Засгийн газрын хувь оролцоо	1,534,123,561.01	1,949,033,682.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,589,667,302.02	1,589,667,302.02
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	1,589,667,302.02	1,589,667,302.02
512	Хуримтлагдсан үр дүн	(146,580,968.69)	232,757,560.28
51210	Өмнөх үеийн үр дүн	(146,580,968.69)	(146,580,968.69)
51220	Тайлант үеийн үр дүн	-	379,338,528.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	91,037,227.68	126,608,819.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,534,123,561.01	1,949,033,682.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,093,136,721.39	3,696,482,183.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	96,170,221.39	397,858,183.25
120	Нийтлэг татварын бус орлого	96,170,221.39	397,858,183.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	96,170,221.39	397,858,183.25
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	556,000.00	4,378,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	95,614,221.39	393,480,183.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,996,966,500.00	3,298,624,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,962,484,900.00	3,191,112,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,962,484,900.00	3,191,112,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,481,600.00	107,511,600.00

**Өвөрхангай аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,917,600.00	48,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		48,720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,564,000.00	10,391,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,150,324,781.49	3,317,143,654.28
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,150,324,781.49	3,317,143,654.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,049,419,056.62	3,217,803,117.13
210101	Үндсэн цалин	1,573,376,929.15	2,557,483,072.34
210102	Нэмэгдэл	1,033,781,863.86	1,330,430,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	309,102,300.00	743,215,759.34
210104	Урамшуулал	113,599,408.13	321,214,442.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,893,357.16	162,622,671.00
210201	Тэтгэврийн даатгал	197,222,547.35	313,515,391.81
210202	Тэтгэмжийн даатгал	122,402,070.00	215,745,700.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,144,484.50	25,586,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	13,956,592.85	12,793,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,156,533.00	11,643,292.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,562,867.00	47,746,199.51
210301	Гэрэл, цахилгаан	33,784,000.63	39,976,909.69
210302	Түлш, халаалт	21,043,422.00	22,527,309.69
210303	Цэвэр, бохир ус	12,451,408.63	16,899,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	289,170.00	550,000.00
210401	Бичиг хэрэг	25,383,510.00	38,958,185.01
210402	Тээвэр, шатахуун	4,628,100.00	2,707,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,178,900.00	30,299,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,253,860.00	4,319,585.01
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,000.00	240,000.00
2105	Нормативт зардал	1,082,650.00	1,391,550.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	503,150.00	81,920.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	57,750.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	445,400.00	81,920.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	41,195,594.03	35,554,080.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	26,722,874.03	15,889,480.00
210604	Урсгал засвар	436,030.00	
2107	Томилолт, зочны зардал	14,036,690.00	19,664,600.00
210702	Дотоод албан томилолт	10,074,900.00	12,381,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	10,074,900.00	12,381,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,831,571.15	56,451,875.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,633,853.15	47,855,664.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,360,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	62,500.00	44,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	3,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	939,000.00	649,060.00
210807	Газрын төлбөр	6,685,348.00	5,324,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,321,920.00	1,213,851.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,046,854.31	163,399,783.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	252,960.00	170,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	152,793,894.31	163,229,783.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,905,724.87	99,340,537.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,089,300.00	87,670,697.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		48,720,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,089,300.00	38,950,697.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,816,424.87	11,669,840.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,816,424.87	11,669,840.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(57,188,060.10)	379,338,528.97
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(57,188,060.10)	379,338,528.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,997,522,500.00	3,303,002,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	556,000.00	4,378,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	556,000.00	4,378,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	556,000.00	4,378,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	556,000.00	4,378,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,996,966,500.00	3,298,624,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,962,484,900.00	3,191,112,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,962,484,900.00	3,191,112,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,481,600.00	107,511,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,917,600.00	48,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	48,720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,564,000.00	10,391,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,970,687,700.00	3,153,785,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,970,687,700.00	3,153,785,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,869,781,975.13	3,054,444,462.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,573,331,076.50	2,557,483,072.34
210101	Үндсэн цалин	1,033,736,011.21	1,330,430,200.00
210102	Нэмэгдэл	309,102,300.00	743,215,759.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	113,599,408.13	321,214,442.00
210104	Урамшуулал	116,893,357.16	162,622,671.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	197,268,400.00	313,515,391.81
210201	Тэтгэврийн даатгал	134,142,500.00	215,745,700.10
210202	Тэтгэмжийн даатгал	15,781,300.00	25,586,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,625,200.00	12,793,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,156,200.00	11,643,292.20
210205	Эрүүл мэндийн даатгал	31,563,200.00	47,746,199.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,724,000.63	38,503,709.69
210301	Гэрэл, цахилгаан	20,944,312.00	22,527,309.69
210302	Түлш, халаалт	15,391,408.63	15,426,400.00
210303	Цэвэр, бохир ус	388,280.00	550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,361,700.00	42,530,325.01
210401	Бичиг хэрэг	4,054,400.00	2,534,610.00
210402	Тээвэр, шатахуун	15,178,900.00	30,299,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,728,600.00	4,582,915.01
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,159,800.00	4,873,100.00
2105	Нормативт зардал	100,000.00	86,720.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	86,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,953,240.00	35,761,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,165,900.00	14,969,100.00
210604	Урсгал засвар	13,787,340.00	20,792,200.00
2107	Томилолт, зочны зардал	10,074,900.00	12,381,900.00
210702	Дотоод албан томилолт	10,074,900.00	12,381,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,715,698.00	53,802,044.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,839,900.00	47,068,744.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,360,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	133,950.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	62,500.00	44,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	3,500.00

Өвөрхангай аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	939,000.00	
210807	Газрын төлбөр	6,685,348.00	5,324,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	252,960.00	380,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	252,960.00	380,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	100,905,724.87	99,340,537.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,089,300.00	87,670,697.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	48,720,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	94,089,300.00	38,950,697.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,816,424.87	11,669,840.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,816,424.87	11,669,840.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	26,834,800.00	149,217,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	26,834,800.00	149,217,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	0.00	0.00	0.00		0.00
C07	Тайлант үеийн үр дүн			0.00		0.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D01	2024 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,589,667,302.02	0.00	-146,580,968.69		1,443,086,333.33
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,589,667,302.02	0.00	-146,580,968.69	0.00	1,443,086,333.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	126,608,819.74	0.00		126,608,819.74
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
D08	Тайлант үеийн үр дүн			379,338,528.97		379,338,528.97
D09	2024 оны 12-р сарын 31-нээрс үлдэгдэл	1,589,667,302.02	126,608,819.74	232,757,560.28	0.00	1,949,033,682.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	төлөвлөгөө	гүйцэтгэл	ЗӨРҮҮ	ХУВЬ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,191,612,400.00	3,183,820,559.85	7,791,840.15	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,191,612,400.00	3,183,820,559.85	7,791,840.15	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,152,636,100.00	3,144,869,862.85	7,766,237.15	99.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,558,683,500.00	2,557,483,072.34	1,200,427.66	100.0
210101	Үндсэн цалин	1,330,430,200.00	1,330,430,200.00	-	100.0
210102	Нэмэгдэл	743,558,100.00	743,215,759.34	342,340.66	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	321,500,200.00	321,214,442.00	285,758.00	99.9
210104	Урамшуулал	163,195,000.00	162,622,671.00	572,329.00	99.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	319,835,400.00	313,515,391.81	6,320,008.19	98.0
210201	Тэтгэврийн даатгал	217,488,000.00	215,745,700.10	1,742,299.90	99.2
210202	Тэтгэмжийн даатгал	25,586,800.00	25,586,800.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,793,400.00	12,793,400.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	12,793,400.00	11,643,292.20	1,150,107.80	91.0
210205	Эрүүл мэндийн даатгал	51,173,800.00	47,746,199.51	3,427,600.49	93.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,678,900.00	38,503,709.69	175,190.31	99.5
210301	Гэрэл, цахилгаан	22,702,500.00	22,527,309.69	175,190.31	99.2
210302	Түлш, халаалт	15,426,400.00	15,426,400.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	550,000.00	550,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,509,900.00	14,503,825.01	6,074.99	100.0
210401	Бичиг хэрэг	2,535,500.00	2,534,610.00	890.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	7,287,200.00	7,287,200.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,878,600.00	2,875,415.01	3,184.99	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, а	240,000.00	240,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,568,600.00	1,568,600.00	2,000.00	99.9
2105	Нормативт зардал	98,700.00	86,720.00	11,980.00	87.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	98,700.00	86,720.00	11,980.00	87.9

**Өвөрхангай аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	161,650,200.00	161,650,200.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	138,958,000.00	138,958,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	22,692,200.00	22,692,200.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	5,518,900.00	5,501,900.00	17,000.00	99.7
210702	Дотоод албан томилолт	5,518,900.00	5,518,900.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	53,280,600.00	53,245,044.00	35,556.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	46,512,100.00	46,511,744.00	356.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,360,800.00	1,360,800.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,300.00	44,500.00	16,800.00	72.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21,900.00	3,500.00	18,400.00	16.0
210807	Газрын төлбөр	5,324,500.00	5,324,500.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	380,000.00	380,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	380,000.00	380,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,976,300.00	38,950,697.00	25,603.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,976,300.00	38,950,697.00	25,603.00	99.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,976,300.00	38,950,697.00	25,603.00	99.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,191,612,400.00	3,183,820,559.85	7,791,840.15	99.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,191,112,400.00	3,179,442,559.85	11,669,840.15	99.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,191,112,400.00	3,179,442,559.85	11,669,840.15	99.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	4,378,000.00	(3,878,000.00)	875.6
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	4,378,000.00	(3,878,000.00)	875.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,481,600.00	107,511,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,481,600.00	107,511,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,481,600.00	58,791,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,376,000.00	28,026,500.00
210401	Бичиг хэрэг	1,934,000.00	
210402	Тээвэр, шатахуун	9,392,000.00	23,012,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,850,000.00	1,707,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	3,306,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,731,440.00	23,328,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,584,800.00	17,958,100.00
210602	Тавилга	-	3,570,000.00
210604	Урсгал засвар	8,146,640.00	1,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,941,200.00	6,880,000.00
210702	Дотоод албан томилолт	4,941,200.00	6,880,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	350,000.00	557,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	350,000.00	557,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,960.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	82,960.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	48,720,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	48,720,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	48,720,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34,481,600.00	107,511,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,481,600.00	107,511,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,917,600.00	48,400,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	48,720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,564,000.00	10,391,600.00

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төв нь ус, цаг уур орчны төлөв байдлын өөрчлөлтийн мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангаж, байгаль цаг агаарын болзошгүй аюул, гамшиг, орчны ноцтой бохирдлоос сэрэмжлүүлэх, гангийн эрсдлийг

бууруулах, ой хээрийн түймрийг унтраах зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулдаг.

БНМАУ ба ЗХУ-ын засгийн газар хоорондын 1940 оны 01 дүгээр сарын 1-ний өдрийн хэлэлцээрийн дагуу тус аймгийн уур амьсгал, ус зүй, цаг агаарын байдлыг шинжлэн судлах зорилгоор байгуулагдсан.

Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/83 тоот тушаалаар баталсан бүтэц орон тооны дагуу нийт 86 албан хаагчтай үйл ажиллагаа явуулж байна.

Тус байгууллага нь Ус цаг уур орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний нэгжүүдийг арга зүй, технологийн удирдлагаар хангаж, тэдний тасралтгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх, хяналт шинжилгээнд ашиглаж буй хэмжих хэрэгсэл, багаж төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ, шалгалт тохируулгыг тогтмол хийж, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг ус, цаг уур орчны мэдээ мэдээллээр хангах чиг үүрэгтэй.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа худалдан авах тухай хууль, Нийгмийн даатгалын болон Татварын хуулиудыг мөрдөж, үйл ажиллагаагаа явуулдаг.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цаг Уур Орчны Шинжилгээний газрын даргын 2023 оны 08 дүгээр сарын 31-ны өдрийн А/116 тоот тушаалаар батлагдсан ЦУОШТөвийн төсөвт байгууллагуудад мөрдөгдөх "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажилладаг. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төвийн 2024 оны санхүүгийн тайланг "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 414.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	13,793.9	55,466.8	41,672.9
Үндсэн хөрөнгө	1,520,329.6	1,893,566.8	373,237.2
Нийт хөрөнгө	1,534,123.6	1,949,033.7	414,910.1
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,589,667.3	1,589,667.3	0.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,534,123.6	1,949,033.7	414,910.1

Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй гарсан. Өглөг, авлага үүсээгүй. Бараа материалын дансны үлдэгдэл нь өмнөх оноос 41.7 сая төгрөгөөр өссөн нь: Цаг уур, орчны шинжилгээний газраас тусгай зориулалтын материалд 34.2 сая төгрөгийн, автомат станцын сэлбэгт 6.6 сая төгрөгийн, аж ахуйн материалд 0.9 сая төгрөгийн бараа материалыг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн байна.

2024 онд үндсэн хөрөнгө 373.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Тайлант онд Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/77 дугаар захирамжаар Хужирт сумын Цаг уурын өртөөний улсын төсвийн санхүүжилтаар баригдсан 222.8 сая төгрөгийн барилгыг хөрөнгөнд бүртгэсэн байна. Цаг уур, орчны шинжилгээний газраас 128.9 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу үнэ төлбөргүй шилжин ирснийг бүртгэсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 792 дугаар тогтоолоор 35.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоосон байна. Ерөнхий гэрээний арга болон гэрээ байгуулан 149.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнийн харьцуулалтын аргаар шууд худалдан авалт хийсэн.

Тайлант хугацаанд 163.2 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,658.8 сая төгрөг, өөрийн орлогоор 0.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

2024 оны төсөвлөсөн төсөв бүрэн батлагдсан. Гүйцэтгэлээр 3,179.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж өөрийн орлогоос 4.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж тухайн онд 11.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 532.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,179.4 сая төгрөг буюу 99.6 хувьтай зарцуулагдсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80801- Үндсэн үйл ажиллагааны зардал	3,203,483.6	3,195,860.8	7,622.8	99.7
2	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулад дэмжлэг	48,720.0	48,720.0	-	100
3	80220- Холбооны суваг ашигласны хөлс	7,944.1	7,943.9	0.2	99.99
4	80806- Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,796.3	38,950.7	154.4	99.93

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд 532.3 сая төгрөгийн тодотгол хийж, орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд авч зарцуулсан байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь тайлант онд бараа нийлүүлэгч компаниудтай ерөнхий гэрээ байгуулан үнийн харьцуулалтын аргаар цахим дэлгүүрээс 141.9 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж

заасны дагуу Өвөрхангай аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно. Аудитыг Чадварлаг Аудит ХХК-ын аудитор П.Байгальмаа гүйцэтгэж, хяналтыг Төрийн аудитын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитын менежер П.Хорлоосүрэн, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өвөрхангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Чадварлаг аудит ХХК-нд 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 01/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын нийт зардлын дүнгээс 1.5 хувиар буюу 49.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 39.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой 29 хуулийн шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэй холбоотойгоор тус байгууллага нь бичиг хэрэг, албан томилолт, шуудан холбоо, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, зардлуудыг нийт 0.09 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.1-д заасан зардлыг өмнөх оноос 0.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн аудитын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзсэн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг FAS программд оруулсан мэдээллийн дагуу тухайн байгууллагын шилэн дансны сайтаас мэдээллийг шалгасан.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай гэж үнэлсэн

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тухайн байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын хувьд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж аваагүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй

5.2 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд мицубиши Л200 маркийн 8703-ӨВА улсын дугаартай автомашины 3,700.0 мянган төгрөгийн их засварын зардлыг капиталжуулалгүй шууд зардалд бичсэн байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4.үнэн зөв байх; 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт:

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлж байна.

5.3 Зөвлөмж

Тус байгуулагад зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/ мянган төгрөгөөр/											
	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд мицубиши Л200 маркийн 8703-ӨВА улсын дугаартай автомашины 3,700.0 мянган төгрөгийн их засварын зардлыг капиталжуулалгүй шууд зардалд бичсэн байна.	1	3,700.0	0.000	0.000	1	3,700.0	0.00	0.00				
Дүн	1	3,700.0	0.000	0.000	1	3,700.0	0.00	0.00		0.00		0.00

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Өвөрхангай аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний төвийн 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР